



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/19/СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Утас: 261663

Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням
Цахим хаяг: sambuunyamyia@audit.gov.mn
Утас: 260949

Аудитын менежер: Д.Энхдалай
Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Утас: 261885

Ахлах аудитор: Л.Нямтөмөр
Цахим хаяг: nyamtumurl@audit.gov.mn

Аудитор: М.Лхагвасүрэн
Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn
Утас: 261740

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3.Аудитын тайлан	8
3.1. Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал.....	9
3.4. Материаллаг байдал	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9. Шилэн дансны мэдээлэл	12
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж	13
5. Менежментийн захидал	14
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ХУНАН
ТАНАА

2021.04.26 № 1312
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хүний эрхийн Үндэсний Комиссын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө худалдан авахаар төлбөрийг урьдчилан шилжүүлсэн, худалдан авах ажиллагааны хууль журам зөрчсөн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, материаллаг хэмжээтэй авлага, өглөг үүсгэсэн, эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийгээгүй зэрэг нийт 311.0 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг давж, холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Толилуулга ба тодруулга”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


\\10.10.26\Bichia\Kherca\Yawsan\Bichia\2021\0426auditin 2-R\Gazar13.Docx

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/			
Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	108,972.8	421,713.8
33	АВЛАГА	11,946.6	257,524.0
34	УРЬДЧИЛГАА	25,089.5	47,232.5
35	БАРАА МАТЕРИАЛ	71,936.8	116,957.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	87,405.0	44,495.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	87,405.0	44,495.6
392	Биет хөрөнгө	87,405.0	44,495.6
393	Биет бус хөрөнгө	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	196,377.9	466,209.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	16,656.9	25,136.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,656.9	25,136.4
413	Өглөг	16,656.9	25,136.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	179,721.0	441,073.0
51	Засгийн газрын хувь оролцоо	179,721.0	441,073.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	108,348.0	108,348.0
512	Хуримтлагдсан үр дүн	62,472.9	323,824.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,900.2	8,900.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	196,377.9	466,209.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,282,979.4	2,086,954.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	18,858.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,282,979.4	2,068,096.3
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,348,754.3	1,825,602.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,348,754.3	1,825,602.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,309,420.6	1,615,220.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	672,484.2	895,189.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,029.0	114,077.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,333.6	77,070.0
2104	Хангамж, бараа материалын зардал	43,451.4	77,087.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	39,826.9
2107	Томилолт, зочны зардал	154,049.8	101,182.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,346.4	47,485.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	213,726.2	263,301.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,333.8	210,381.4
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-65,775.0	261,352.0

5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-65,775.0	261,352.0
---	--	------------------	------------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/			
Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,310,175.0	2,087,190.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.0	19,094.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,310,175.0	2,068,096.3
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,310,175.0	2,087,190.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,310,175.0	2,087,190.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,270,841.2	1,740,758.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	655,872.1	919,216.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,984.2	116,398.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,333.6	59,133.6
2104	Хангамж, бараа материалын зардал	44,135.9	92,964.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	160,698.1
2107	Томилолт, зочны зардал	169,496.4	100,778.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,592.0	136,553.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221,427.1	155,015.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,333.8	346,432.1
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.0	00.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	00.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	00.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/					
Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
C01	2018 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	108,348.0	8900.2	128,247.8	245,496.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	245,496.0
C07	Тайлант үеийн үр дүн		-	-65,775.0	-65,775.0
C08	2019 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	108,348.0	8,900.2	62,472.9	179,721.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,348.0	8,900.2	62,472.9	179,721.0
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	261,352.0	261,352.0
D09	2020 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	108,348.0	8,900.2	323,824.9	441,073.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

					/төгрөгөөр/
Эдийн засгийн ангилал	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,577,516,100.00	1,502,975,029.17	74,541,070.83	95.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,577,516,100.00	1,502,975,029.17	74,541,070.83	95.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,441,870,200.00	1,367,774,297.17	74,095,902.83	94.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	839,933,300.00	839,933,300.00	00.00	100.0
210101	Үндсэн цалин	630,191,000.00	757,529,665.48	-127,338,665.48	120.2
210102	Нэмэгдэл	164,974,200.00	66,690,355.78	98,283,844.22	40.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,768,100.00	15,713,278.74	29,054,821.26	35.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,919,700.00	112,919,700.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	79,322,200.00	103,715,151.22	-24,392,951.22	130.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,399,400.00	2,375,346.77	6,024,053.23	28.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,719,500.00	1,883,477.60	4,836,022.40	28.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,679,900.00	449,611.52	1,230,288.48	26.8
210205	Эрүүл мэндийн даатгал	16,798,700.00	4,496,112.89	12,302,587.11	26.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,133,600.00	59,133,600.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	119,182,100.00	92,964,113.00	26,217,987.00	78.0
210401	Бичиг хэрэг	10,296,300.00	6,877,200.00	3,419,100.00	66.8
210402	Тээвэр, шатахуун	30,516,400.00	27,489,413.00	3,026,987.00	90.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,369,400.00	25,187,500.00	181,900.00	99.3
210404	Ном, хэвлэл	28,000,000.00	28,010,000.00	-10,000.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,000,000.00	5,400,000.00	19,600,000.00	21.6
2106	Эд хогшил худалдан авах	130,000,000.00	129,338,816.69	661,183.31	99.5
210601	Багаж, техник хэрэгсэл	90,000,000.00	89,341,030.00	658,970.00	99.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	40,000,000.00	39,997,786.69	2,213.31	100.0
2107	Томилолт, зочны зардал	26,607,200.00	26,007,087.00	600,113.00	97.7
210701	Гадаад албан томилолт	16,484,200.00	16,484,187.00	13.00	100.0
210702	Дотоод албан томилолт	10,123,000.00	9,522,900.00	600,100.00	94.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	118,553,700.00	85,565,166.48	32,988,533.52	72.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,349,900.00	82,361,366.48	32,988,533.52	71.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	198,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,005,800.00	3,005,800.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,540,600.00	21,912,514.00	13,628,086.00	61.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,645,900	135,200,732	445,168.00	100
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	24,600,000.00	24,600,000.00	00.00	100.0

2132	Бусад урсгал шилжүүлэг	111,045,900.00	110,600,732.00	445,168.00	99.6
	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	101,898,900.00	101,898,832.00	68.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,147,000.00	8,701,900.00	445,100.00	95.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,577,516,100.00	1,502,975,029.17	74,541,070.83	95.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	60	51	9	85.0
620001	Удирдах ажилтан	4	6	-2	150.0
620002	Гүйцэтгэх ажилтан	52	39	13	75.0
620003	Үйлчлэх ажилтан	4	6	-2	150.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТӨЗ цэвэр дүн
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	490,580,199.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	490,580,199.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372,984,548.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	79,283,323.00
210102	Нэмэгдэл	17,713,302.00
210105	Гэрээт ажлын хөлс	61,570,021.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,478,636.00
210201	Тэтгэврийн даатгал	3,478,636.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,359,240.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,359,240.00
2107	Томилолт, зочны зардал	74,771,368.00
210702	Дотоод албан томилолт	74,771,368.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,988,780.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,988,780.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,103,201.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	133,103,201.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,595,650.14
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	117,595,650.14
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	117,595,650.14
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	490,580,199.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	490,580,199.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	490,580,199.04

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн дансанд төвлөрүүлж байх, төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх, авлага, өглөг үүсгэхгүй байх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн эд хөрөнгө худалдан авч байх, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх, жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө тооллого хийж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Л.Нямтөмөр, аудитор М.Лхагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 6/401 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүний эрхийн Үндэсний Комисс “Хараат бус байр суурийг чанд баримталж, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, хамгаалах, хөхүүлэн дэмжих чиг үүргээ шинжлэх ухаанчаар, мэргэжлийн түвшинд явуулж, хэлэлцэж, зөвшилцөж, бусдаас тасралтгүй суралцаж, олон ургалч, хариуцлагатай, эвсэг, мэргэшсэн баг, тааламжтай ажиллах орчин бүрдүүлэх замаар эрхэм зорилгодоо хүрнэ” хэмээн зорилгоо тодорхойлж дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах;
- Хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал өгөх;
- Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх;
- Комиссын гишүүн Улсын Их Хурлын чуулган, Засгийн газрын хуралдаанаар хүний эрхтэй холбогдсон асуудал хэлэлцэхэд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын хүсэлтээр зөвлөх эрхтэй оролцох, хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, шүүхээр шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэргийн материалтай танилцах, холбогдсон хууль, тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий албан тушаалтан, байгууллагад уламжлах.

Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлага дараах хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль;

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Татварын багц хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тамгын газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй, дотоод хяналт хангалтгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,751.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 35.0 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133.6 сая төгрөгөөр буюу 68.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	11,946.6	257,524.0	245,577.4
Бараа материал	71,936.8	116,957.3	45,020.5
УТЗардал/тооцоо	25,089.5	47,232.5	22,143.0
Үндсэн хөрөнгө	87,405.0	44,495.6	- 42,909.4
Нийт хөрөнгийн дүн	196,377.9	466,209.4	269,831.5
Өр төлбөр	16,656.9	25,136.4	8,479.5
Эздийн өмч	179,721.0	441,073.0	261,352.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	196,377.9	466,209.4	269,831.5

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, өглөгийн данс материаллаг өөрчлөлттэй байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 257.5 сая төгрөг болж 245.6 сая төгрөгөөр өссөн нь хувь хүний орлогын албан татварт 10.3 сая төгрөг урьдчилан шилжүүлсэн, Хүний эрхийн үндэсний байгууллагын хөгжил, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай ном, сэтгүүл, хэвлүүлэх бичиг хэргийн зардалд 28.2 сая төгрөг, үндсэн хөрөнгө худалдан авахаар 48.9 сая төгрөг, баримтат кино хийлгэхээр 6.0 сая төгрөг, ажлын хувцас тараах материал, ковид-19 вирусээс сэргийлэх хамгаалах хэрэгсэл худалдан авахаар 27.8 сая төгрөг тус тус урьдчилан шилжүүлээд авлагаар тайлагнаснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 117.0 сая төгрөг болж 45.0 сая төгрөгөөр өссөн нь иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудад тараах зорилгоор ном товхимол, сэтгүүл, сурталчилгааны хуудас зэргийг хэвлүүлэхэд 4.6 сая төгрөг, Европын холбооны төслийн төсөвт тусгагдсан санхүүжилтээр 40.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Урьдчилж төлсөн тооцооны дансны үлдэгдэл 47.2 сая төгрөг болж 22.1 сая төгрөгөөр өссөн нь 2021 оны байрны түрээсийн төлбөрт 47.2 сая төгрөг урьдчилан шилжүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 25.1 сая төгрөг болж 8.5 сая төгрөгөөр өссөн нь хувь хүний орлогын албан татварын өглөг 16.6 сая төгрөгийг төлж, Европын Холбооны төслийн санхүүжилтээр гүйцэтгэх "Туслах малчдын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хүний эрхийн хэрэгжилт" сэдэвт судалгааны ажлын гүйцэтгэлийн төлбөр болох 25.1 сая төгрөгийн өглөг үүссэнээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,359.3 сая төгрөгөөр төсөвлөсөн боловч, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталж Комиссын дэргэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулагдсантай холбоотой хуульд заасан чиг үүрэг өргөжсөнөөр үйл ажиллагааны төсөв, орон тоо нэмэгдэж цалин хөлс, ажлын байрны түрээс, хөрөнгө оруулалтын зардал зэргээс шалтгаалан 681.7 сая төгрөгийн төсвийг нэмж тодотгол оруулан дээд шатны төсвийн захирагчид нийт 2,041.0 сая төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөн хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 463.5 сая төгрөгөөр бууруулж 1,577.5 сая төгрөгөөр батлагдсан.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх “Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих” хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,238.4 сая төгрөг, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 339.1 сая төгрөг нийт 1,577.5 сая төгрөгийн төсөв баталсныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,577.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,503.0 сая төгрөгийг зарцуулж 74.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,503.0 сая төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь хангамжийн материалын зардлыг 26.2 сая, эд хогшил худалдан авах зардлыг 0.7 сая, томилолтын зардлыг 0.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 33.0 сая, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 13.6 сая, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 0.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар Европын холбоо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын хамтын сан зэрэг байгууллагуудаас нийт 490.6 сая төгрөгийн нэмэлт төсвийн орлогыг бүрдүүлэн ажилласан байна.

Үүнээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд 79.3 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3.5 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 31.3 сая, томилолт, зочны зардалд 74.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 51.0 сая, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын ангилалд 133.1 сая, нийт 373.0 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 117.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд улсын төсвийн хөрөнгөөр 3.2 сая төгрөгийн амны хаалт, бээлий, дархлаа сайжруулах эм, нүүрний хаалт, гар ариутгагч зэрэг хэрэгсэл худалдан авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө худалдан авахаар төлбөрийг урьдчилан шилжүүлсэн, худалдан авах ажиллагааны хууль журам зөрчсөн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, материаллаг хэмжээтэй авлага, өглөг үүсгэсэн, эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийгээгүй зэрэг нийт 311.0 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн асуудлаар гаргасан гомдлыг шийдвэрлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээлгэх

талаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шаардлага хүргүүлэх, зэрэг ажлуудыг хийх зорилт дэвшүүлэн зорилтот түвшиндээ хүрсэн байна.

3.9. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 117 мэдээллээс 77 мэдээллийг хугацаанд нь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан бусад байршуулбал зохих 34 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 429.3 сая, зарлагын 145.6 сая төгрөгийн 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан байна.

3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	0	1	0	100.0
Зөвлөмж	3	16.6	1	16.6	33.3
Нийт дүн	4	16.6	2	16.6	50.0

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын даргын 2020 оны А/19 дүгээр тушаалаар НБББББ-ийг шинээр баталсан нь өмнөх аудитаар өгсөн 1 зөвлөмж, санхүүгийн тайланг Acolous программаар бэлтгэн гаргаж байх гэсэн 1 албан шаардлага биелсэн бөгөөд өглөгийн үлдэгдэлгүй байх, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байршуулахгүй байх гэсэн 2 зөвлөмж хэрэгжээгүй, нийт хэрэгжилт 50 хувьтай байна.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсан.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 311.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 164.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 146.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 164.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Бэлтгэн нийлүүлэгчээс тараах материал, ажлын хувцас нийт 18.0 сая төгрөгийн бараа материалыг шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "...бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-т "...техникийн саналын шаардлага хангасан 3 ба түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх" заалт, Босго үнийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон босго үнийн хязгаартай тус тус нийцэхгүй, Санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд 121.3 сая төгрөгийн авлага, 25.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, авлага өглөг үүсгэхгүй байх, албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 117 мэдээллээс 77 мэдээллийг хугацаанд нь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан бусад байршуулбал зохих 34 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 429.3 сая, зарлагын 145.6 сая төгрөгийн 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 146.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

5. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Засгийн газрын 11 дүгээр байрны 2021 оны түрээсийн төлбөрт 47.2 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д *"Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдээгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ"*, 43.5-д *"Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй байх"* заалтуудыг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл:

Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн байх, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахгүй байх;

1.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулагдаагүй үлдээгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлж байх, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах;

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч цаашид урьдчилж гарсан зардал үүсгэхгүй ажиллана.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэргүйгээр 37.3 сая төгрөгийн оффисын тавилга, 52.0 сая төгрөгийн компьютер хэрэгсэл худалдан авахаар урьдчилан шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т *"Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно."*, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан *"Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх"* журмын 1.2-т *"Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ"* гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Хууль журам хэрэгжихгүй байх, дотоод хяналт сул байх, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахгүй байх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн эд хөрөнгө бэлтгэж байх;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, цаашид Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмыг мөрдөж ажиллана.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

2001-2014 онуудад худалдан авсан 376.9 сая төгрөгийн элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь УСНББОУС 17-д Үндсэн хөрөнгө дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт хөрөнгийн бодит үнэ цэнэ, ашиглалтын хугацааг тооцож үздэг байх, шаардлагатай бол хөрөнгийг дахин үнэлэх, мөн тус стандартын Элэгдүүлэх дүн ба элэгдүүлэх хугацаа хэсэгт *"Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой"*, ТӨБЗГ-ын 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд *"Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох"*, заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Холбогдох стандарт, хууль, журам, зааврыг мөрдөөгүй байх, хөрөнгийн үнэлгээ тодорхой бус байх

3.3. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хугацаанд нь хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д *"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна"*, 12.2-т Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1-т *"жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйл *"Эд хөрөнгийн тооллогын бэлтгэлийг хангах"* заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь бүрэн хийгээгүй байх, холбогдох хууль, журам хэрэгжихгүй байх, дотоод хяналт сул, эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байх;

4.3. Өгсөн зөвлөмж:

Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө тооллого хийж байх;

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч цаашид жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө буюу тайлант ондоо багтаж эд хөрөнгийн тооллогыг хийж ажиллана

5. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Гар сканер, ажлын үнэмлэхний уут, мэдээллийн самбар, хулдаасан хэвлэл зэрэг 10.1 сая төгрөгийн барааг бүлэг хооронд шилжүүлэн Хөдөлмөр, хамгааллын хэрэгслийн зардлаас санхүүжүүлж худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", 41 дүгээр зүйлийн 41.2-т *Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ*, 41.2.3-т "*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах*", Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам "*Бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх*" заалтуудыг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх, холбогдох хууль тогтоомж, Сангийн сайдын тушаал шийдвэр хэрэгжихгүй байх

5.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэрийг мөрдөж төсвийг бүлэг хооронд шилжүүлэхгүй байх;

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч цаашид төсвийн зардлыг бүлэг хооронд шилжүүлэхгүй, зориулалтын дагуу зарцуулж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хавсралт

Огноо:	Аудитын нэр:	Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/19/СТА-ТЕ3
Шалгагдсан байгууллагын нэр:	Хүний эрхийн Үндэсний комисс		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Бэлтгэн нийлүүлэгчээс тараах материал, ажлын хувцас нийт 18.0 сая төгрөгийн бараа материалыг шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн	18.0	Албан шаардлага	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хунан, С.Нармандах
2	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд 121.3 сая төгрөгийн авлага, 25.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна	146.4	Албан шаардлага	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хунан, С.Нармандах
3	Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 117 мэдээллээс 77 мэдээллийг хугацаанд нь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан бусад байршуулбал зохих 34 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 429.3 сая, зарлагын 145.6 сая төгрөгийн 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй	-	Албан шаардлага	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хунан, С.Нармандах
4	Засгийн газрын 11 дүгээр байрны 2021 оны түрээсийн төлбөрт 47.2 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн байна	47.2	Зөвлөмж	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хунан, С.Нармандах
5	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэргүйгээр 37.3 сая төгрөгийн оффисын тавилга, 52.0 сая төгрөгийн компьютер хэрэгсэл худалдан авахаар урьдчилан шилжүүлсэн байна	89.3	Зөвлөмж	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хунан, С.Нармандах
6	2001-2014 онуудад худалдан авсан 376.9 сая төгрөгийн элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	-	Зөвлөмж	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хунан, С.Нармандах
7	Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хугацаанд нь хийгээгүй байна.	-	Зөвлөмж	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хунан, С.Нармандах
8	Гар сканер, ажлын үнэмлэхний уут, мэдээллийн самбар, хулдаасан хэвлэл зэрэг 10.1 сая төгрөгийн барааг бүлэг хооронд шилжүүлэн Хөдөлмөр, хамгааллын хэрэгслийн зардлаас санхүүжүүлж худалдан авсан.	10.1	Зөвлөмж	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хунан, С.Нармандах
ДҮН		311.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 558/АДМ10001

Улаанбаатар хот

САГ- 002/13/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүний эрхийн Үндэсний комиссын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бэлтгэн нийлүүлэгчээс тараах материал, ажлын хувцас нийт 18,005.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "...бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийг тус тус баримтлаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллах, дээрх зөрчлийг арилгах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, ерөнхий нягтлан бодогч С.Нармандах нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 557/АОМ10001

Улаанбаатар хот

СЯГ-2021/19/СТЯ-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, мөн тайлант онд 121.3 сая төгрөгийн авлага, 25.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, ерөнхий нягтлан бодогч С.Нармандах нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 553/АОИ/0001
САН-2021/19/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүний эрхийн Үндэсний комиссын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим мэдээлэлд байршуулбал зохих 117 мэдээллээс 40 мэдээллийг хугацаа хоцроож, хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт болон худалдан авах ажиллагааны жилийн тайланг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, хуулийн хугацаанд бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, ерөнхий нягтлан бодогч С.Нармандах нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ